

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДУГАР ОВОГТОЙ РЭНЧИНДОРЖИЙН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: **Эрдэнэтчүүд бид эхлүүлж чадна.**

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрвээ ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот ажлууд мөн тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг томъёолж өгсөн болно.

1.Эрдэнэт - Иргэддээ үйлчилдэг хот

1.1.Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй цахим хэлбэрт шилжүүлэх

1.2.Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулж иргэдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг хангана.

2.Эрдэнэт – Мэдээлэл технологийн хот


2.1. Мэдээлэл технологийн бизнесийн гарааны эко системийг бүрдүүлэх

2.2.Гадаадад техник , технологи чиглэлээр ажиллаж, суралцаж буй Эрдэнэтчүүдийг төрөлх хотынхоо хөгжилд татан оролцуулах “Эрдэнэт-хөгжлийн эхлэл” хөтөлбөр боловсруулж,хэрэгжүүлэх

3.Цэвэр хот - Эрүүл иргэн

3.1. Эрүүл мэнд, биеийн тамир, спортын тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтэрүүлэх, , өвчнийг эрт илрүүлэх, оношлох, үйлчилгээ үзүүлэх талаар иргэн төвтэй, салбар дундын уялдаа, залгамж холбоог дэмжсэн бодлого, механизм, менежментийн орон зайг бий болгох хөтөлбөрүүд боловсруулж ажиллах.

3.2. Гэр хороололд амьдарч буй иргэдэд агаар хөрсний бохирдлыг арилгах тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор цэвэр, бохирын шугам, халаалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр УИХ, ЗГ, холбогдох яамд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж эхлүүлнэ. Хогны менежментийг сайжруулж, хог боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана.



4.Эрдэм мэдлэгтэй залуусын хот

4.1. “Орос,Англи хэлтэй Эрдэнэт хот” төслийг хэрэгжүүлэх

4.2.Номын сангийн хүртээмжийг нэмэгдүүлж цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах

5.Ажилтай орлоготой бүтээгч иргэд

5.1.Ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангах , ажлын байр олноор бий болгох тал дээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

5.2. Эрдэнэт үйлдвэрийн хэрэгцээг хангах – Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан болон бусад сангуудын үйл ажиллагааг ил тод болгож хүртээмжтэй байхад анхаарч дэмжин ажиллах

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан.....Д.Рэнчиндорж

